

**БНХАУ-ын Сургалтын Төвд олон улсын цахим сургалтанд
хамрагдсан товч тайлан**

2021.05.19

Хятадын Цаг Уурын Байгууллагын Сургалтын Төвөөс 2021 оны 04-р сарын 19-нөөс 30-ны хооронд зохион явуулсан “Хүчтэй конвекцийн үзэгдлийг хэт богино хугацаанд урьдчилан мэдээлэх арга, арга зүй” сэдэвт цахим зайн сургалтанд Мэдээлэл Үйлчилгээний Хэлтэс, Нислэгийн Цаг Уурын Өртөөний дараах нэр бүхий албан хаагчид хамрагдлаа. Үүнд:

1. Б.Сүхбаатар – Ерөнхий технологич инженер
2. Г.Ганболд – Ахлах синоптик инженер
3. М.Чулуунтөмөр – НЦУӨртөөний инженер
4. С.Баярдулам – НЦУӨртөөний инженер

Сургалт агуулга:

1. Суурь мэдлэг /конвекцийн үзэгдэл, доплер радар, тоон прогнозын үр дүнгүүд/
2. Танилцуулга /Сургалтын тухай, Хятадын цаг уурын байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагаа, Хятадын цаг уурын байгууллага сургалтын төв/
3. Хүчтэй конвекцийн үзэгдлийг хэт богино хугацаанд урьдчилан мэдээлэх арга, арга зүйнүүд, тоон прогнозын үр дүнгүүд
4. MICAPS-4 систем
5. Гамшгаас урьдчилан сэргийлэх, бууруулах, цаг уурын үйлчилгээ
6. форум, хаалтын ажиллагаа /шалгалт, бие даах ажил/

Уг сургалтанд цахимаар голчлон Ази, Африк, Европ тивээс, Өмнөд Америк, Австрали тивийн улсуудаас харьцангуй цөөн, нийт 355 хүн оролцсон.

Сургалтанд Хятадын Цаг Уурын Байгууллага /ХЦУБ/-ын Сургалтын Төвийн багш нараас гадна Хятадын Цаг Уурын Байгууллагын Үндэсний цаг уурын төв болон Урьдчилсан мэдээний төвийн ажилтнууд шинээр ХЦУБ-д одоо ашиглагдаж буй SWAN, MICAPS4 системүүдийн тухай хичээл заасан нь маш сонирхолтой, үр дүнтэй байлаа. Сүүлийн үед урьдчилан мэдээлэх үйлчилгээнд нэвтэрсэн онол, арга зүйн шинэ шинэ мэдээлэл өгсөн үр дүнтэй сургалт болсон гэж дүгнэж байна.

Боломжтой бол цаашид Хятадын Цаг Уурын Байгууллагатай холбогдож урьдчилсан мэдээний цогц систем MICAPS-4, SWAN (Severe Weather Automatic Nowcasting) зэрэг програм хангамжийг ашиглан туршиж үзвэл НЦУТ-д хийгдэж буй нислэгт зориулсан тоон загварын үр дүнг зураглах ажилд болон урьдчилсан мэдээний чанарт эерэг нөлөө үзүүлж болох юм.

Тайлан бичсэн:

Ерөнхий технологич инженер  Б.Сүхбаатар